ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS RESEARCH CENTER

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Банкуудын өрсөлдөөний тойм

3-р улирал, 2019



- Банкны салбарын мэдээ, мэдээлэл
- Үндсэн үзүүлэлтүүд
- Онцлох сэдэв: Орон нутгаарх зээл олголт
- Арилжааны 13 банкны актив, зээл, хадгаламж, ашгийн хэмжээ

Банкны салбарын эргэн тойронд

07.05 – Дэлхийн банкны гишүүн байгууллага болох Олон улсын санхүүгийн корпораци Хас банканд 65 сая ам.долларын санхүүжилт олгох гэрээнд гарын үсэг зурлаа. xacbank.mn

07.09 – Банкны зээл олгох журмын төслийг танилцууллаа. mongolbank.mn

07.25 – Төрийн банкнаас харилцагчиддаа урьдчилгаа төлбөргүй Ногоон зээлийн үйлчилгээг санал болголоо. statebank.mn

08.06 – "Худалдаа, хөгжлийн банк, нярайн эндэгдлийг бууруулах чиглэлээр **"Хязгааргүй мөрөөдөл"** төслийг санаачлан, хэрэгжүүлж эхлэлээ. tdbm.mn

08.07 – Их дээд сургуулийн оюутан залууст зориулсан "Зорилготой оюутан" хөтөлбөрийг эхлүүллээ. golomtbank.com

08.09 – Global Finance сэтгүүлээс Голомт банкийг Монгол Улсын "Шилдэг дижитал банк"-аар тодруулаа. golomtbank.com

08.12 – Банкны салбарын Хангайн бүсийн удирдах ажилтны зөвлөгөөн боллоо. mongolbank.mn

08.20 – GME Мөнгөн шилжүүлгийн үйлчилгээг нэвтрүүллээ. nibank.mn

09.03 – Хаан банк Азийн хөгжлийн банкны худалдааны санхүүжилтийг дэмжих хөтөлбөрийн "Монгол дахь шилдэг хамтрагч банк"-аар дахин тодорлоо. khanbank.com

09.05 – Монголын банкны холбооны Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулагдаж, Худалдаа, хөгжлийн банкны Ерөнхийлөгч Б.Мэдрээ олонхын саналаар сонгогдлоо. tdbm.mn

09.05 – Тээвэр хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал М.Отгонбаяр Монголын банкны холбооны дэд ерөнхийлөгчөөр сонгогдлоо. transbank.mn

09.06 – Худалдаа, хөгжлийн банк нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, тэдний нийгэмд оруулах хувь нэмэр, дуу хоолойг дэмжих зорилго дор Ахиллис Монгол Олон улсын байгууллагатай 3-н жилийн хугацаанд хамтран ажиллах санамж бичигт өнөөдөр гарын үсэг зурлаа. tdbm.mn

09.12 – Хаан банк жилийн 8 хувийн хүүтэй "Ногоон зээл" олгож эхэллээ. khanbank.com

09.17 – Худалдаа, хөгжлийн банк нь Ахиллис Монгол олон улсын Байгууллагаас зохион байгуулдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэд тамирчдыг дэмжих, тэдэнд урам зориг, эрч хүч, өөртөө итгэх итгэлийг өгөх зорилготой марафон гүйлтийг ивээн тэтгэж, хамтран зохион байгууллаа. tdbm.mn

09.20 – Капитрон банк олон улсын үнэлгээний Moody's агентлагаар зээлжих зэрэглэлээ тогтоолголоо. capitronbank.mn

09.22 – Голомт банк өөрийн үйл ажиллагааг "Тогтвортой хөгжлийн зорилтууд" болон "Парисын гэрээний уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилтуудтай" уялдуулахаа тунхаглалаа. golomtbank.com

09.23 – Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журмыг танилцууллаа. mongolbank.mn

09.24 – Тээвэр хөгжлийн банк JCI Улаанбаатар ТББ-ын "Иргэн бүр аврагч" төслийн 2019 оны хамтын ажиллагааныхаа хаалтыг хийлээ. transbank.mn

09.25 – Богд банк Английн INTL FCStone Inc. олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгууллаа. bogdbank.com

09.27 – Хаан банк "Нийгмийн даатгалын шилдэг шимтгэл төлөгч - ажил олгогч" байгууллагаар дахин тодорлоо. khanbank.com

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2019 он – III улирал

Банкны салбарын гол үзүүлэлтүүд[1]



Нийт актив = 34,9 их наяд төгрөг

Банкны салбарын нийт актив 2019 оны 3-р улиралд 34,9 их наяд төгрөг болж өмнөх улирлаас 1,1 их наяд (+0,6%) төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3,9 их наяд (+0.1%) төгрөгөөр өслөө.



Алдагдал = -31,6 тэрбум төгрөг

Банкуудын өөрийн хөрөнгө 2019 оны 3-р улирлын байдлаар 3,0 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0,01 их наяд төгрөгөөр буурчээ. Харин банкны салбарын ашиг 3-р улирлын байдлаар 31,6 тэрбум төгрөгийн алдагдалтай байна. Их хэмжээний алдагдал нь Капитал банкны дампуурлаас хамааралтай юм.



Банкны нөөц = 4,7 их наяд төгрөг

Банкны нөөц 2019 оны 3-р улирлын байдлаар 4,7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1,6 их наяд төгрөгөөр өсчээ. Харин өмнөх улиралтай харьцуулахад 351 тэрбум төгрөгөөр өссөн байна.



Чанаргүй зээл 11,7%

Нийт дотоодын зээл (цэвэр) өссөөр 2019 оны 3-р улирлын байдлаар 16.7 их наяд төгрөгт хүрээд байна. Харин чанаргүй зээлийн хэмжээ өндөр түвшинд хэвээр байна. 3-р улирлын байдлаар нийт чанаргүй зээл 1,9 их наяд төгрөг буюу нийт зээлийн (цэвэр) 11,7%-ийг эзэлж байна.

[1] *Эх сурвалж: Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд, Монголбанк*

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2019 он – III улирал

Ипотек = 4,53 их наяд төгрөг

Ипотекийн зээлийн үлдэгдэл 2019 оны 3-р улирлын байдлаар 4,53 их наяд төгрөг буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,1%-иар өссөн байна.

1 USD = 2669 MNT 1 CNY = 375 MNT

Монголбанкнаас зарласан ханшийн сарын дундаж хөдөлгөөнөөр 2019 оны 9-р сарын дундаж Ам.доллар-ын ханш 2669₮, Юань-ийн ханш 375₮ байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ам.долларын ханш 166₮-р (+10%), Юанийн ханш 10₮-р (+2,7%) тус тус өссөн байна.



Харилцах+Хадгаламж=18,5 их наяд ₮

2019 оны 3-р улирлын байдлаар банкны салбарын нийт хадгаламжийн хэмжээ 12,6 их наяд төгрөг, харилцах 5,9 их наяд төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж 13,5%-иар, харилцах 22,0%-иар өссөн байна.



Пассив = 31,8 их наяд төгрөг

2019 оны 3-р улирлын байдлаар банкны салбарын нийт пассив (өр төлбөр) 31,8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3,9 их наяд (+13,9%) төгрөгөөр өсчээ.



Онцлох: Орон нутгийн зээл олголт

2019 оны 9-р сарын байдлаар 21 аймгийн 659 мянган зээлдэгчдийн нийт банкны зээлийн үлдэгдэл 4,3 их наяд төгрөг байна. Үүнээс 97,5% (4,1 их наяд төгрөг) нь хэвийн, хугацаандаа төлөгдөж байгаа бол үлдсэн 2,5% нь хугацаа хэтэрсэн эсвэл чанаргүй зээлийн ангилалд байна.

Доорх графикт харуулснаар Орхон аймаг хамгийн их буюу 352,3 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа бол Говьсүмбэр аймаг хамгийн бага буюу 70,1 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. 2019 оны 9-р сард олгогдсон зээлүүдийн жигнэсэн дундаж хүүний хувьд Говьсүмбэр болон Дархан-Уул аймгуудад хамгийн бага буюу 15,1 хувийн хүүтэй, Сэлэнгэ аймагт хамгийн өндөр буюу 20,1 хувийн хүүтэй зээлүүд олгогдсон байна.

Орон нутгийн 4,3 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдлийн 2,2 их наяд төгрөг буюу 51% нь цалин, тэтгэврийн зээл байна.



Банкуудын өрсөлдөөн

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2019 оны 3-р улирлын байдлаар банкны салбарт нийт 13 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор банкны системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно. Үүнд:

- Актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Ашиг

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, бусад банкууд гэж ангилсан

	АКТИВ	БАНКУУД
ТОМ-3 БАНК	>5 их наяд төгрөг	Худалдаа хөгжлийн банк Хаан банк Голомт банк
ДУНД-3 БАНК	1-5 их наяд төгрөг	Хасбанк Төрийн банк Улаанбаатар хотын банк
ЖИЖИГ БАНКУУД	<1 их наяд төгрөг	Чингис хаан банк Капитрон банк Үндэсний хөрөнгө оруулалтын банк Ариг банк Богд банк Кредит банк Тээвэр хөгжлийн банк

АКТИВ

Тайлант хугацаанд тайланд орсон 13 банкны нийт актив 34,9 их наяд төгрөг байна. Том-3 банк нийт активын 69,6%, Дунд-3 банк 22,4%, жижиг банкууд 8%-ийг эзэлж байна.

1 жилийн өмнөх мөн үетэй харьцуулахад том-3 банкны актив 15%, дунд-3 банкны актив 9%, жижиг банкуудын актив 33%-иар тус бүр өсчээ.



Банкуудын активын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь







ЗЭЭЛ

Тайлант хугацаанд тайланд орсон 13 банкны нийт зээлийн үлдэгдэл 17,1 их наяд төгрөг байна. Үүнээс 65,5%-г Том-3 банк, 26,2%-г Дунд-3 банк 8,7%-г жижиг банкууд бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 11%-иар, Дунд-3 банк 11%-иар, жижиг банкууд 50%-иар тус тус зээлийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Харин нийт дүнгээр авч үзвэл банкуудын зээлийн хэмжээ сүүлийн нэг жилд 13,5% өсчээ.



Зээлийн хэмжээ, тэрбум төгрөг болон өсөлтийн хувиар







ХАДГАЛАМЖ БА ХАРИЛЦАХ

Тайлант хугацаанд тайланд орсон нийт 13 банкны харилцах ба хадгаламжийн хэмжээ 22,4 их наяд төгрөг байна. Үүнээс 67,3%-г Том-3 банк, 25,8%-г Дунд-3 банк, 6,7%-г жижиг банкууд эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 20%-иар, Дунд-3 банк 33%-иар, жижиг банкууд 33%-иар тус бүр харилцах ба хадгаламжийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Нийт дүнгээр нь авч үзвэл харилцах болон хадгаламжийн хэмжээ 24%-иар өсчээ.



Хадгаламж ба харилцахын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлт





АШИГ

2019 оны 3-р улирлын байдлаар тайланд орсон 13 арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд нийт 219 тэрбум төгрөгийн ашигтай[2] (татварын дараах дүн) ажиллажээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банкны ашиг 37%-иар буюу 77 тэрбум төгрөгөөр өсч 287 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Дунд-3 банкны ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 тэрбум төгрөгөөр өсч 25,7 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Харин жижиг банкуудын хувьд 36,5 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Банкуудын ашиг, алдагдал (тэрбум төгрөгөөр):







Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень 3У’19, Монголбанк
2. Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд 3У’19, Монголбанк
3. Монголбанкны ханшийн сарын дундаж хөдөлгөөн, Монголбанк
4. Арилжааны банкуудын улирлын санхүүгийн тайлан 3У’19
5. Арилжааны банкуудын зээлийн тайлан, 2019 оны 9-р сар

[2] *Капитал банкны мэдээлэл ороогүй тул ашгийн хэмжээ Монголбанкны нэгдсэн тайлангаас өөр болно.*